



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/64

Мандалговь

“Ус цэвэршүүлэх төхөөрөмж” нийлүүлэгчийг
сонгон шалгаруулах Үнэлгээний хороо
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Ус цэвэршүүлэх төхөөрөмж” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Түвшинбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

Гишүүд: Ц.Бямбацогт (Иргэний төлөөлөл)

Д.Мөнхцоож (Хот тохижуулах газрын ахлах
мэргэжилтэн)

Д.Даариймаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын
хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: М.Бат-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн газрын ХАА
хариуцсан мэргэжилтэн)

Хоёр. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Түвшинбаяр)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060261